



СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/156

Алтанбулаг

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Голд Булаг” ХХК-ний “Номин” хүнсний дэлгүүр тамхи худалдах тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгосугай.

2. Тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл авсан “Голд Булаг” ХХК-ний “Номин” хүнсний дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг сумын Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч (Г.Энхтүвшин), Байгаль орчин хяналтын улсын байцаагчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч (О.Отгонтөгс), 1 дүгээр багийн Засаг дарга (Э.Зориг), Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (Б.Отгонбилэг) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (А.Баярчимэг)-д үүрэг болгосугай.



Н.ОТГОНЦОГТ